

## Гарчиг

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	3
1.1 Районы физик газарзүйн товч тодорхойлолт.....	3
1.2 Тусгай зөвшөөрлийн талбайн геологийн судалгааны товч түүх.....	5
1.2.1 Геологийн тогтоц.....	7
2. БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	8
2.1 Газрын гадарга, геологийн тогтоцод үзүүлэх нөлөөлөл.....	8
2.2. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл.....	8
2.3. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл.....	8
2.4. Усны нөөц, чанарт үзүүлэх нөлөөлөл.....	9
2.5. Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл.....	9
2.6. Сумын нийгэм, эдийн засагд үзүүлэх нөлөөлөл.....	10
3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЙЛАН.....	11
3.1 2021 оны нөхөн сэргээлтийн тайлан.....	21
4. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН.....	22
1.2. Хяналт шинжилгээ явуулах төрөл, хэлбэр:.....	22
1.3. Байршил.....	22
1.4. Хийх ажлын дараалал:.....	22
1.5. Хяналт шинжилгээ явуулах хугацаа, давтамж:.....	23
1.6. Хэрэглэгдэх багаж төхөөрөмж.....	23
1.7. Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал:.....	23
Хоёр. Хөрсний хяналт шинжилгээ.....	23
2.1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл.....	23
2.2. Хяналт - шинжилгээ явуулах үзүүлэлт:.....	23
2.3. Байршил.....	23
2.4. Хийх ажлын дараалал.....	23
2.5. Хяналт-шинжилгээ явуулах хугацаа, график.....	24
2.6. Хэрэглэгдэх багаж төхөөрөмж.....	24
2.7. Аргачлал.....	24
2.8. Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ.....	24
Гурав. Газар доорх усны хяналт шинжилгээ.....	24
3.1. Усан орчинд узуулэх нөлөөлөл.....	24
3.2. Хяналт-шинжилгээ явуулах үзүүлэлт.....	24
3.3. Хяналт-шинжилгээний төрөл хэлбэр.....	24
3.4. байршил.....	24
3.5. Хэрэглэгдэх багаж төхөөрөмж.....	24
3.6. Хийх ажлын дараалал.....	24
3.7. Хяналт-шинжилгээ явуулах хугацаа график.....	24
3.8. Аргачлал.....	25
5. 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЙЛАНГИЙН НИЙТ ЗАРДАЛ.....	26

## Хавсралт зураг

## ОРШИЛ

Монгол улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Ашигт малтмалын тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, Засгийн газрын холбогдох тогтоолууд, Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яамнаас гарсан мөрдөгдөж буй журам, стандартууд, БОНХЯ-ны сайдын 2014-01-06-ны №А-05 тушаалаар батлагдсан "Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тухайн жилд хэрэгжүүлэх Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам" зэрэг эрх зүйн баримт, материалууд дээр үндэслэн боловсруулав.

“Эм Жи Жи И Си ”ХХК нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших Ар наймган нэртэй 2,4 га талбайд техникийн нөхөн сэргээлтийн ажлыг 2023 оны 06 сараас 10 сар хүртлэх хугацаанд гүйцэтгэв. Намрын тариалалтаар урд онд бэлдсэн 8,4 га талбайн 4,02 га хэсэгт биологийн олон зүйлд ургамал тарьж биологийн нөхөн сэргээлтийг хийв. Мөн Дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 3,88 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийв.

Энэхуу тайланд "**Ар наймган**" төслийн үйл ажиллагаатай холбогдон бий болж болзошгүй сөрөг нөлөөллөөс тухайн нутаг дэвсгэрийн Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны зорилтууд, нөлөөллийг бууруулахаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэл, хуваарийн дагуу ажилласан болно.

## 1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

### 1.1 Районы физик газарзүйн товч тодорхойлолт

Ар наймганы амны алтны шороон орд нь Хэнтийн уулсын баруун урд хэсэгт, Туул голын ай савын доод хэсэгт оршино.

Нөхөн сэргээлт хийсэн талбай нь топопланшет М-48-137 дээр байрлана.

MV-004411, MV-004412, MV-00129 тоот тусгай зөвшөөрлийн талбайд орших “Ар наймган-1” үүсмэл ордын солбицолыг доор үзүүлэв.

#### Талбайн өнцөгийн солбицолууд

Хүснэгт № 1


№	Өргөрөг	Уртраг
1	48	18
2	48	18
3	48	18
4	48	18
5	48	18
6	48	18
7	48	18
8	48	22
9	48	22
10	48	22
11	48	22
12	48	22
13	48	22
14	48	22

Засаг захиргааны харъяалалын хувьд MV-004411, MV-004412, MV-00129 ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбай нь Төв аймгийн Заамар сумын нутаг дэвсгэрт хамаарна.

Ордоос зүүн тийш 35 км зайд сургууль, эмнэлэг, холбоо, худалдаа үйлчилгээ хөгжсөн Заамар сумын төв орших ба ордоос баруун урагш 3км-т сургууль, эмнэлэг, холбоо, худалдаа үйлчилгээ бүхий “Шижир алт”-ны уурхайн Өгөөмөр тосгон ба “Алтандорнод Монгол” ХХК-ийн уурхайн суурин байрлана.

Томоохон хот суурин болох Улаанбаатар, Дархан хотууд хайгуулын талбайгаас 230 км ба 240 км, Эрдэнэт хотоос 160км зайд тус тус алслагдсан байна.

Зураг №1



Сүүлийн жилүүдэд Заамарын бүсэд шороон ордууд маш хурдацтай ашиглагдаж байгаа учир жилийн аль ч улиралд автомашинаар зорчих, ажил үйлчилгээ явуулах бүрэн боломжтой. Заамарын хүдрийн болон шороон алтны зангилааны алтны шороон ордуудыг ашиглахтай холбогдуулан 110 кв ба 35 кв-ийн өндөр хүчдэлийн шугам баригдсан.

Дүүрэг нь эрс тэс уур амьсгалтай. Өвөл 1-р сард  $-37^{\circ}$  хүрдэг ба 9-р сарын сүүл 10-р сарын эхээр сэрүүсдэг. 3-р сараас хаврын дулааны урь орж 4-р сараас цас хайлж дуусдаг. Жилийн дундаж хур тунадас 360 мм унах ба 85% нь зуны улиралд буудаг. Олон жилийн цэвдэг байхгүй, өвөл хөрс нь 2-2,5 м-т хөлддөг байна. Салхи нь голчлон хойноос, баруун хойноос 3,5 м/сек, салхины жилийн дундаж хурдтай ба хавар зарим тохиолдолд 20 м/сек хүрдэг. Газар зүйн хувьд ажлын талбай нь Заамарын нурууны хойд тал Туул голын баруун эрэг орчимоор байрлана. Хамгийн өндөрлөг цэг нь далайн түвшинээс 1815 м-т байрлах Заамар уул, ихэнх хэсэг нь өндөрт орох бөгөөд өндрийн цэг 1500-1700 м байна. Хамгийн нам дор газар нь Туул голын хөндийд 935 м, талбайн төв хэсэгт – 1040 м Харьцангуй өндөржилт нь Ар наймганы хөндийн хамгийн ойр орших өндөрлөгтэй холбож үзэхэд 150-200 м-т хэлбэлзэнэ.

Заамарын депресс нь дүүргийн зүүн өмнөд хэсэгт байрлах ба энэ нь өмнөд зүгт чиглэсэн аажим уналттай ба талын өндөршлийн цэг нь 1250-1060 м хооронд



хэлбэлзэнэ. Талбайн гадаргуугийн усан сүлжээ нь Туул гол, түүний баруун цутгал ам хөндийгөөс бүрдэнэ.

Туул голын гольдролын өргөн нь 30-100 м-т хэлбэлзэх ба усны гүн зарим хэсэгтээ 3,0 м хүрдэг. Туул голын баруун цутгал Ар наймганы хөндий нь хэрчигдэл багатай, бага хэмжээний устай бөгөөд хөндийн урт 19 км үргэлжилнэ.

Туул гол болон түүний цутгалууд нь 10-р сараас 3-р сарын сүүлч болтол хөлддөг бөгөөд түүний өргөн нь 30-100 м-т хүрдэг. Талбай нь Заамарын алтны хүдрийн зангилааны төв хэсэгт байрладаг учраас цахилгаан хангамж, авто замын сүлжээ, усан хангамж, түлш, модон материалаар уурхайг хангахад эдийн засгийн хувьд нөхцөл сайтай, үр ашигтай болох нь тодорхой юм.

## **1.2 Тусгай зөвшөөрлийн талбайн геологийн судалгааны товч түүх**

Заамарын алтны хүдрийн зангилааны алтны шороон хуримтлалын талаар эрт дээр үеэс мэдэгдэж байсан ба эртний алт олборлогчдын ашиглаж байсан ухмалын бүдгэрсэн ул мөр Туул голын хөндийн баруун талын өндөр дэнжүүдээр, мөн Баянгол, Цагаан булаг, Урт сайр, Тосонгийн хөндийд үлдсэн байдаг.

Дүүргийн геологийн тогтоцын анхны судалгааг 1950-иад оны сүүлээр эхэлж В.А.Ботевату ба А.М. Арсентьева нар 1958 онд 1:1 000 000 масштабын геологийн зураг зохиосон.

Заамарын нурууны ар талд буюу Туул голын сав газрын доод хэсэгт 1979-1981 онуудад В.Довжид, Д.Жамцаа нарын (Заамарын эрэл-зураглалын анги) удирдлага дор алтны шороон ордын эрлийн ажлыг анх явуулж, Заамарын алтны хүдрийн зангилаанд шороон ордын нөөцийн тойм үнэлгээ өгсөн.

Алтны шороон хуримтлалын эерэг үр дүнг харгалзан 1981 оноос эхлэн Дарханы Геологийн экспедиц Заамарын алтны хүдрийн зангилаанд алтны шороон ордын эрэл ба хайгуулын ажлыг явуулсаны үр дүнд Хайлааст, Туул, Тосон зэрэг 20 орчим алтны шороон ордыг илрүүлэн тогтоосон байна.

Мөн 1987-1991 онуудад Зөвлөлтийн геологийн экспедици, монгол-зөвлөлтийн хамтарсан Дарханы экспедицүүд Заамарын хүдрийн зангилгаанд 1:50000-ын масштабын геологийн зураглалын ажлыг гүйцэтгэсний үр дүнд Заамарын хүдрийн

зангилгаа алтны шороон болон хүдрийн илэрцүүдийн үнэлгээ, ирээдүйн судалгааны шинжилгээний ажлын үндсэн чиглэлийг тодорхойлсон байна. (Б.Пүрэвсүрэн, Н.Г.Эйдельман 1991 он).

Ар наймганы хөндийн доод хэсэгт үйлдвэрлэлийн ач холбогдол бүхий алтны шороон ордыг 1990 онд анх олж илрүүлсэн ба монгол-зөвлөлтийн хамтарсан геологийн Дарханы экспедицийн өрөмдсөн 16 ба 32 шугамуудын үр дүн нь цаашид нарийвчилсан хайгуулын ажил явуулах үндэслэл болсон юм.

Нарийвчилсан хайгуулын ажлыг 1993 оноос монгол-оросын хамтарсан “Монгол Алт” компани гүйцэтгэсэн бөгөөд 1993-1994 онд С.Цэрэн-Очир, О.В.Степанов нар Ар наймганы хөндийн доод хэсгийн алтны шороон ордын (төв хэсэгт) хайгуулын ажил явуулж, С<sub>1</sub> зэргээр 5929,2 кг алтны нөөц тогтоосноос гадна, Ар наймганы хөндийн хэмжээнд Р<sub>1</sub> зэргээр 2,3-10,0 тн алтны таамаг нөөцийн үнэлгээ өгчээ. Хөндийн доод хэсэгт байрлах алтны шороон ордод “Алтандорнод монгол” ХХК 1999 оноос эхлэн 2016 хүртэл ашиглалт явуулж байсан болно.

“Улзгол” ХХК 2017 оноос хөндийн доод хэсэгт байрлах 4411А тусгай зөвшөөрлийн талбайд болон “Илтголд” ХХК хөндийн дунд хэсэгт байрлах 4412А тусгай зөвшөөрлийн талбайд хайгуулын ажлыг гүйцэтгэн өрмийн 42-60-р шугамуудын хооронд алтны шороон ордын балансын нөөцийн хүрээг тогтоосон юм.

2006-2007 онд гүйцэтгэсэн алтны шороон ордын хайгуулын ажлын үр дүнгээр геологич В.Н.Дрягалов нар Ар наймганы хөндийн дунд хэсэгт 8757Х талбайн хүрээнд нийт үйлдвэрлэлийн нөөцийг В зэрэглэлээр 264,4 кг, тодорхой нөхцөлд ашигтай нөөцийг 9,3 кг гэж тооцсон бөгөөд нийт хайгуулаар тогтоогдсон нөөц В зэрэглэлээр 273,7 кг болж байна.

Ашиглалтын 5028А талбайд явуулсан хайгуулын ажлын үр дүнд В зэргээр 1826,8 кг алтны үйлдвэрлэлийн, мөн В зэргээр 301,5 кг тодорхой нөхцөлд ашигтай нөөцийг тооцоолсон. Нийт хайгуулын ажлын үр дүнд В зэргээр 2091,2 кг алтны нөөцийг ЭБМЗ-д оруулж батлуулсан байна. Өнөөгийн байдлаар “Алтандорнод монгол” ХХК хайгуулын ажлыг Ар наймганы дунд хэсгийн зүүн өмнөд жигүүрт (5028А талбай) нэмэлт нарийвчилсан хайгуулын ажлыг үргэлжлүүлэн Ар наймганы хөндийн дээд эхээд үргэлжлэх шороон ордыг мөрдөн судалж байгаа юм.

### 1.2.1 Геологийн тогтоц

Төслийн талбай нь хойд Хэнтийн алтны хүдэржилтийн бүсийн Шарын голын хүдрийн зангилаанд байрладаг. Хойд Хэнтийн структур, формацийн бүсэд дунд кембрий, доод ордовикийн үеийн субдукцийн бүсийн аккрецийн шаантагийн гаралтай Хараагийн серийн флиш маягийн терриген хурдас, дунд юра, доод цэрдийн үеийн уулс дундын мульд маягийн грабенд үүссэн Шарын голын свитийн молассын хурдсууд болон түрүү девоны I, II фацийн интрузив чулуулаг болох дунд том ширхэгтэй сул шүлтлэг лейкократ ба плагио боржин, габбро-диорит, дэл судлын чулуулаг тархаснаас гадна орчин үеийн сэвсгэр хурдас голын хөндий тэдгээрийн цутгалуудад тархсан байдаг.

**Геологийн тогтоц.** Ашиглаж угаасан болон хөрс хуулж овоолго хийгдсэн цоохор өнгийн (Q<sub>iv</sub>) хурдас нь тухайн үед (2004-2005 он) уурхайн дотоод овоолго болох улаан, саарал өнгийн сэвсгэр хурдсаар эргэн тойрон болон ул хэсгээр хилэлсэн байрлалтай оршино.

**Дээд плиоцены хурдас (N<sub>2</sub><sup>2</sup>).** Энэ насны хурдас тоосгон улаан, хүрэн улаанаас боровтор улаан өнгийн шавраас бүрдэх ба маш муу мөлгөржилттэй цөөн тооны чулуулгийн жижиг хэмхдэс агуулсан бөгөөд шавар нь маш нягт, тослог шинжтэй, угаагдах шинж чанар муутай байдаг.

Энэ хурдсыг тухайн үед хөрс хуулалт явуулж уурхайн ухмал хэсгийг дүүргэлт хийсэн байдлаар ажиглагдах ба алтны үүсмэл ордын нөөц бодогдсон хэсэглэлүүдийн ул суурь, хажуу хэсгээр хил залгана.

Ар наймганы алтны шороон ордод өрөмдсөн цооногуудын зүсэлтээс үзэхэд, доорхи нийтлэг зүсэлт ажиглагдана.

## 2. БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Өмнө уурхай ажиллаж байх үеийн нөлөөллүүдийг байгаль орчны голлох бүрэлдэхүүнүүдээр тодорхойлсныг дараах хүснэгтэд харуулав.

### 2.1 Газрын гадарга, геологийн тогтоцод үзүүлэх нөлөөлөл

Хүснэгт №2

Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын чанарын үнэлгээ		
	Бага	Дунд	Их
Уурхайн карьерийн хананд ачаалал үүсч, чулуулгийн бүтэц өөрчлөгдөх	+		
Уурхайн тээврийн явцад олон салаа зам үүсэх, тоосжилт үүсэх	+		
Ахуйн болон механизмын шингэн, хатуу хог хаягдлын улмаас хөрс бохирдох хүний эрүүл мэндэд нөлөөлөх	+		

### 2.2. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх нөлөөлөл

Олборлолт явуулж байх үед тус талбайд шавранцар хүрэн хөрс тархсан бөгөөд хээрийн судалгаагаар энэ хөрсний энэ хөрсний үржил шимт зузаан 0.2-0.25 метр байна.

Хүснэгт №3

Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын чанарын үнэлгээ		
	Бага	Дунд	Их
57 га талбайн шимт хөрсийг хуулсан, 10.0 мян. м <sup>3</sup>			+
Үржил шимт хөрсний овоолгын хөдөлгөөнт фосфор, азот, ялзмагь солилцох калийн хэмжээ буурсан.		+	
Хөрс хуулалт, олборлолтын ажлын үед болон суваг шуудуу татсанаас хөрсний элэгдэл эвдрэл үүссэн.		+	
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр хөрсөн бүрхэвч элэгдэлд орж зөөгдсөн.	+		
Машин механизмын утаанаас ялгарах хорт бодис нь зам орчны хөрсөнд, улмаар малын өвс тэжээлийн чанар, хүний эрүүл мэндэд муугаар нөлөөлсөн байдал.	+		

### 2.3. Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл

Уул уурхайн үйл ажиллагаагаар ургамлан нөмрөгт үзүүлсэн сөрөг нөлөөллийн хэлбэрүүд болон хэмжээг доорх хүснэгтэнд үзүүлэв.

Хүснэгт №4

Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын чанарын үнэлгээ		
	Бага	Дунд	Их
57 га талбайн ургамалын нөмрөг устсан.		+	
Олборлолтын явцад гүний усны түвшин буурч хөрсний	+	+	

чийг багасах улмаар ургамалын бүлгэмдэл, зүйлийн тоо өөрчлөгдөж болзошгүй байдал.			
Уурхайн барилга байгууламжийн дор ургамал дарагдсаны улмаас устаж, ойр орчинд талхлагдал үүссэн	+		
Салаа зам их гаргавал ургамалын талхлагдал үүсэх эрсдэл	+		
Хүнд даацын автомашин, механизмын түлшний шаталтаас үүссэн хорт утаанд ургамал бохирдож амьдрах чадвараа алдах	+		
Уурхайн бүхий л үйл ажиллагаанаас үүсэх тоосонд орчны талбайн ургамал дарагдаж амьдрах чадвараа тодорхой хэмжээгээр алдах	+		

#### 2.4. Усны нөөц, чанарт үзүүлэх нөлөөлөл

Сөрөг нөлөөлөл	Хүснэгт№5 Нөлөөллийн үр дагаврын чанарын үнэлгээ		
	Бага	Дунд	Их
	Газрын доорх болон гадаргын усны нөөц горим чанар өөрчлөгдсөн	+	
Усны түвшин доошилж улмаар нутгийн иргэдийн гар худгийн ундарга багасах, ширгэх	+		
Олборлолтын явцад газар доорх усыг ил гаргаж гадаргын усны ууршилтыг ихэсгэх	+		
ШТМ, хатуу, шингэн хог хаягдлаар газар доорх ус бохирдсон	+		

#### 2.5. Амьтны аймагт үзүүлэх нөлөөлөл

Алт олборлох уйл ажиллагаанаас амьтны аймагт үзүүлэх болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр болон нөлөөллийн эрчмийг доорх хүснэгтэнд үзүүлэв.

Сөрөг нөлөөлөл	Хүснэгт№6 Нөлөөллийн үр дагаврын чанарын үнэлгээ		
	Бага	Дунд	Их
	Хөхтөн амьтан ялангуяа цагаан зээрийн тархалт нутгийг хумих бэлчээр тэжээлийн доройтолд орох	+	
Уурхайтай хобоотойгоор бэлчээрийн ургамал талхлагдаж устсанаас мал бэлчээргүйтэх	+		
Тодорхой хугацаанд хүн амын нягтрал бий болсноор элдэв ан агнах оролдлого бий болох	+		
Амьтны нуудэл гүйдлийн замд саад болох	+		
Орчны мэрэгч амьтад уурхайн уйл ажиллагааны нөлөөгөөр устах	+		

Уурхайн ухмалд мал, амьтан унах	+		
---------------------------------	---	--	--

## 2.6. Сумын нийгэм, эдийн засагд үзүүлэх нөлөөлөл

Уурхайн уйл ажиллагаанаас сумын нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийн үнэлгээ

Хүснэгт №7

Сөрөг нөлөөлөл	Нөлөөллийн үр дагаврын чанарын үнэлгээ		
	Бага	Дунд	Их
<b>Сөрөг нөлөөлөл</b>			
Малын бэлчээрийг хязгаарлах малчдын эрх ашгийг хөндөх	+		
Шуугиан, хүний хөдөлгөөн ихсэж, хүн амын тайван байдал, эрүүл мэндэд нөлөөлөх	+		
Хүн амын төвлөрөл тодорхой хэсэст бий болсноор элдэв хэрэг төвөг гарах хандлага бий болох	+		
<b>Эерэг нөлөөлөл</b>			
Нөхөн сэргээлтийн төслийн талбай нь аюулгүй байдал хангагдах, бэлчээрийн зориулалтаар биологийн нөхөн сэргээлт хийгдэнэ			+
Мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүнийг төслийн компанид худалдаснаар иргэдийн орлого нэмэгдэнэ.		+	
Орон нутгийн иргэдээс тодорхой тооны иргэдийг ажлын байраар хангах		+	

Дээрх хүснэгтээс харахад уурхайн зүгээс сум орон нутгийн нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл нь бага, эерэг нөлөөлөл нь таатай байна.



### **3. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТАЙЛАН**



Зураг 3.1 Уурхайн газар ашиглалтын байдал

"Эм Жи Жи И Си" ХХК нь 2021 онд Төв аймгийн Заамар сумын нутагт орших “Ар наймган” нэртэй МҮ-00129 талбайд 9.3 га техникийн нөхөн сэргээлт – дотоод овоолгын ажлыг үргэлжлүүлэн хийж урд жилүүдийн цэвэр бохирын нуурын талбайг дүүргэн нөхөн сэргээлт хийж гүйцэтгэв. Мөнхүү МҮ-021836 талбайд 8,4 га талбайд техникийн нөхөн сэргээлт дотоод, гадаад овоолго, хэлбэршүүлэх ажлыг явуулж биологийн нөхөн сэргээлтэд бэлтгэв. Мөн Баянголын аманд дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 5 га газарт техникийн нөхөн сэргээлт-гадаад овоолгын ажлыг явуулав.

Техникийн нөхөн сэргээлтийн ажлыг нийт 2 ширхэг Northbenz, 2 ширхэг ХОВО 371 маркийн автосамосвал, 1 ширхэг САТ-349 маркийн экскаватор, 2 ширхэг SD-300 маркийн дугуйт ачигч, 1 ширхэг Коматцу маркийн бульдозер тус тус оролцон урд жилүүдэд “Алтандорнод” ХХК ний хаягдал нуурын ухмал нүх хэсэгт дүүргэхэд дотоод овоолго тэгшлэх, хаягдал овоолгыг ухмал нүх хэсэгт дүүргэлтийг гүйцээж анхдагч гадаргуутай ижил түвшинд болгон биологийн нөхөн сэргээлт хийхэд бэлэн болгосон юм.

Техникийн нөхөн сэргээлт – дотоод овоолгын 2,4 га талбай нь ухмал нүхийг дүүргэх замаар хийгдэж байгаа бөгөөд ажлын явц 100% тай явж байна. Үүнд: Үүсмэл ордын элсийг баяжуулах явцад гарсан шороог зөөж нүхийг дүүргэх.

Техникийн нөхөн сэргээлт - гадаад овоолгын ажил нь нийт 17, 7 га талбайг хамарсан бөгөөд налуу гадаргууг орчных нь гадаргуутай ойртуулан тэгшилж хэлбэршүүлж үржил шимт хөрс дэвссэн болно.

Зураг 3.2 Дүүргэлтийн ажил гүйцэтгэж байгаа нь



Зураг 3.3 Шимт хөрсөн хучилтын ажил явагдаж байгаа



□ **Биологийн нөхөн сэргээлт:**

Биологийн нөхөн сэргээлтийг техникийн нөхөн сэргээлтээр дүйцүүлэн 2023 онд төлөвлөж байсан 1,7 га техникийн нөхөн сэргээлтийг 2,4 га болгон техникийн нөхөн сэргээлтээр гүйцэтгэсэн болно. 2022 онд гүйцэтгэсэн 8,4 техникийн нөхөн сэргээлт



хийж гүйцэтгэсэн талбайд хөрсний тогтоцоос хамааран 2023 оны намар биологийн нөхөн сэргээлтийг 4,02 үржил шимт олон наст ургамал тарьж үлдэсэн 4,4 га талбайд 2024 онд тариалалт хийхээр төлөвлөж байна.

□ **Мод тарьж ургуулж үрээр үрслүүлэх.**

Орон нутгийн хөрс ургамлын онцлогоос шалтгаалж өөрсдийн авчирсан мод бутны ургалтын явцад дасан зохицох чадвар нь харилцан адилгүй ургаж байгаагаас үзэхэд урт хугацааны хамгийн чухал нь маш сайн арчилгаа шаардлагатай байгааг илтгэж байна. Тиймээс тухайн орон нутагт нутагшсан дасан зохицсон ургамал мод бутныг тарих нь нэн чухал юм байна.

2023 онд өөрсдийн хүлэмж арьчилгааны хэсэгт 2 жил үрслүүлэн бэлдсэн 6000 гаруй хайлаас тарьсан ба нэмэлт үржил шимт хөрс, бууц бордоог ашиглан ургамлыг хортон шавьжаас урьдчилан сэргийлэх бүх л арга техник, арга ажиллагааг туршиж графикт арчилгаа усалгааг цаг хугацаанд хийж ургуулж, арчилж, сайжруулан ажилласнаар ахиц дэвшилттэй байна.

Дараах мод бутныг үндсэн 4 хэсэгт буюу 1 га талбайд 13 нэр төрлийн модыг ойжуулуулах үржүүлэх цэцэрлэгжүүлэх зорилгоор төгөл болгон тарьж ургуулан ажиллаж байна.

- Жимсний мод бутныг тарьж үржүүлэх төгөл 1.1 га
- Модыг үрээр үрслүүлж ургуулах төгөл
- Навчит мод бутныг тарьж ургуулах төгөл 5.5га
- Кемпийг зүлэгжүүлж, цэцэрлэгжүүлэх Ногоон орчин төгөл 1 га (Ажилчдынхаа эрүүл аюулгүй амьдрах таатай орчин нөхцлийг нь хангах ) зэргээр төрөлжүүлэн дэс дараатай үйл ажиллагааг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

□ *2023 Тарьж ургуулсан модыг төрөл зүйлээр нь ангилахад:*

№	Модны нэр төрөл	Тоо ширхэг	Нас	Гарал үүсэл	Хэмжээ
2	Хайлаас	6000	2	өөрийн	70-120
15	Нийт	<b>6000 ш</b>			

Дараа онуудад тарьж ургуулах зорилгоор орон нутгийн хөрсөнд нутагшиж дассан модны үрийг түүж үрсэлгээ хийсэн.

№	Үрийн төрөл	Тоо	Гарал үүсэл	Ургалт
1	Улиас	1000	Улаанбаатар	500ш
3	Улиас сибирь	1000	Орон нутаг СОВ	700ш
4	Хайлаас	2кг	Б	5500ш
		<b>9500ш</b>		<b>6700ш</b>

Зураг 3.4 2 настай Улиасны суулгац тариалалт- Байгаль орчны баг



Зураг  
ажилчид

3.5 Нийт  
“

Үндэсний  
өдөр”-өөр  
үрсэлгээ 600  
суулгасан.



Мод тарих  
Бургасны  
ширхэгийг



Зураг 3.6 Ойжуулах чиглэлээр нөхөн сэргээлт хийсэн талбай





Мөн түүнчлэн энэ онд 2023 оны нөхөн сэргээлтийн талбайд хайлаас модыг харандаалж 6000 ширхэг суулгацыг үржүүлэн 2024 онд суулган арчилан ажиллаж байна.

Нөхөн сэргээлтийн талбайгаас гадна уурхайн ажилчдын амрах орчин болох кэмшийн орчимд ногоон байгууламж байгуулан, хашаалж, нийт ажилтнуудын хүнсний хэрэглээнд дотоод нөөц болоцоогоо ашиглан 2 шуудай буюу 80 кг үрийн төмс, хүрэн манжин, байцаа зэрэг хүнсний ногоо, өргөст хэмх, улаан лооль, хулуу, гоньд, амтат чинжүү, редиск зэрэг нарийн ногоо, чацарганы төгөлөөс 50 кг чацаргана, үхрийн нүд, бөөрөлзгөнө, тарвас зэрэг жимсний бутнуудыг ургуулж, арчлан, хурааж аван шинэ



ургацын  
бүтээгдэ  
хүүнүүд  
ийг  
хэрэглэ  
ж байна.

Зураг  
3.13  
Ойжуул  
ах  
чиглэлээ  
р нөхөн



сэргээлт хийсэн талбай













Зураг 3.14 Заамар сумын Хайлааст багийн төвд мод суулгаж байна.

Аймаг, сум орон нутгийн төрийн байгууллагын шаардлага хүсэлтийн дагуу хийх гүйцэтгэх ажлын хүрээнд Хайлааст багийн төвд 60 ш хайлаас мод ны суулгацыг суулгасан болно. Мөн Заамар сумын төвийн баруун хойд Халзангийн давааны зам засварын ажилд сумын тамгын газраас 1 компаниас 55 рейс явуулах хүсэлт гаргаснаас манай компани 88 рейс гүйцэтгэсэн байна.



### 3.1 2022 оны нөхөн сэргээлтийн тайлан

Хүснэгт №8

хэрэгжүүлсэн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хэрэгжүүлэгч	Биелэлтийн шалгуур	Баримтлах хууль стандарт
Техникийн нөхөн сэргээлт хийсэн МҮ-000129	Урд жилүүдийн олборлолтод өртсөн талбай	Га	2,4	“Эм Жи Жи И Си”ХХК	Техникийн нөхөн сэргээлт стандарт, шаардлагад нийцсэн байх	MNS 5917:2008
Биологийн нөхөн сэргээлт хийхэд бэлэн талбай МҮ-000129	Техникийн нөхөн сэргээлт хийсэн талбай	Га	4,02	“Эм Жи Жи И Си”ХХК	Техникийн нөхөн сэргээлт стандарт, шаардлагад нийцсэн байх	MNS 5918:2008
Дүйцүүлэн хамгаалах талбай	Урд жилүүдийн олборлолтод өртсөн талбай	Га	3,88	“Эм Жи Жи И Си”ХХК	Техникийн нөхөн сэргээлт стандарт, шаардлагад нийцсэн байх	MNS 5917:2008

#### **4. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТАЙЛАН**

“Эм Жи Жи И Си” ХХК-нь нөхөн сэргээлтийн үйл ажиллагаа явуулах хугацаандаа суурингаас гарах хог хаягдлын хэмжээг эх үүсвэрт нь бууруулах, гарсан хог хаягдлыг байгаль орчинд бохирдол багатайгаар зайлуулах, ангилан ялгав. Суурингаас ахуйн лонх, лааз, цаас, хоолны үлдэгдэл, бусад гэсэн байдлаар нь ангилан хадгалж дахин ашиглагдах хэсгийг нь хоёрдогч түүхий эдийн цэгт нийлүүлэн, үлдэх буюу ашиглагдахгүй хэсгийг хогийн цэгт зайлуулав.

Зураг 4.1 Ажилчдын хотхон



#### **Хяналт шинжилгээ явуулах зайлшгүй үзүүлэлтүүд:**

- NO<sub>2</sub>, CO, 502, CH<sub>4</sub>-ийн агууламж,
- Тоосонцорын /PM 10/ агууламж

#### **1.2. Хяналт шинжилгээ явуулах төрөл, хэлбэр:**

- Дээжлэгч уутанд сорьц авах /NO<sub>2</sub>, CO, 502, CH<sub>4</sub>-ийн агууламж/
- Автомат хэмжилтийн багажаар тодорхойлох /PM 10/

#### **1.3. Байршил**

##### **Автомашинууд**

- Уурхайн карьер, угаах төхөөрөмжийн орчим

#### **1.4. Хийх ажлын дараалал:**

- Тогтоосон хугацаанд сонгосон цэгт багажийг байрлуулж агаарын дээжийг авна.
- Хэмжилт хийх үеийн агаарын температур, салхины хурд, чиглэл, агаарын харьцангуй чийг зэрэг үзүүлэлтүүдийг тодорхойлж тэмдэглэл хөтөлнө.
- Тоосны тувшний хэмжилтийг зориулалтын автомат багажны тусламжтайгаар

хэмжилтийг гуйцэтгэнэ.

1.5. Хяналт шинжилгээ явуулах хугацаа, давтамж:

- Жилд 1 удаа /9 сард/

1.6. Хэрэглэгдэх багаж төхөөрөмж

- Тоосны хэмжилтийн зөөврийн автомат станц
- Агаарын дээжлэгч уут

#### **4.1. Хяналт шинжилгээ явуулах арга, аргачлал:**

- Бензин хөдөлгүүртэй автомашин-угаан найрлага дах хорт бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга ММ55013:2009

- Дизель хөдөлгүүртэй автомашин —Угааны тортогжилтын зөвшөөрөгдөх дээд хэмжээ ба хэмжих арга МГ455012:2009

- МГ]5 5003:2000. Чимээ шуугианы-Хөдөлмөр хамгаалал, эрүүл ахуй. Чимээ шуугианыг хэмжих

- МГ15 0017-5.1.21:92. Автотээврийн хэрэгслийн дуу чимээ, дуу чимээний хүлцэх түвшин, хэмжих арга

- МГ\15 0012-013:1991. Ажлын байрын агаар. Ажлын байрны агаарын бус

- Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ:

- MNS 0012-013:91. Ажлын бусийн агаар. Эрүүл ахуйн шаардлага

- Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэм хэмжээ. Техникийн ерөнхий шаардлага, MNS 5885 : 2008

- M5 5002:2000. Чимээ шуугиан. Хөдөлмөрийн аюулгүй байдал, ариун цэвэр. Чимээ шуугианы хэм хэмжээ болон аюулгүй байдлын ерөнхий шаардлага

- МГ15 4990:2000. Ажлын байрны орчин. Эрүүл ахуйн шаардлага

#### **4.2. Хөрсний хяналт шинжилгээ**

2.1. Хөрсөнд үзүүлэх нөлөөлөл

- Уурхайн талбайд болзошгүй химийн болон бусад бодисын тархалт

2.2. Хяналт - шинжилгээ явуулах үзүүлэлт:

- Хөрсний өнгөн үе давхаргын агро химийн үндсэн үзүүлэлт, зонхилох ион, давсжилт

- Cu, V, Cd, Cr, As, Se, Mo, Pb, F, %, Zn, CN нийт зэрэг хүнд металлын бохирдлын түвшинг тодорхойлуулах

2.3. Байршил

- Уурхайн карьер, угаах төхөөрөмжийн орчим
- Ажилчдын байрны ойролцоо

2.4. Хийх ажлын дараалал

- Хөрсний зүсэлт хийх (0.5-1.0 м гун).
- Орчин, хөрсний гадарга, хөрсний зүсэлтийн фото зураг авна.
- Хөрсний зүсэлтийн морфологи бичиглэл хийнэ
  - Дээж авалт (дээж тус бүр гун, өнгө, ...солбицол бичсэн хаягтай байна)
  - Итгэмжлэгдсэн лабораторит хүргүүлэн задлан шинжилгээ хийлгэнэ.

2.5. Хяналт-шинжилгээ явуулах хугацаа, график

- Жилд 1 удаа /9 сард/

2.6. Хэрэглэгдэх багаж төхөөрөмж

- Зүсэлт хийх хүрз
- Хөрс дээжлэгч уут, сан
- Фото аппарат

2.7. Аргачлал

- MNS 3985-87 Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл
- MNS 3310-91 Хөрсний агро химийн үзүүлэлтийг тодорхойлох
- МГ15 3298-1991 Хөрс. Шинжилгээний дээж авахад тавигдах ерөнхий шаардлагууд
- ММ5 2305-94 Дээж авах, савлах, тээвэрлэх, хадгалах журам

2.8. Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ

- Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ МГ15 5850:2008.

### 4.3. Газар доорх усны хяналт шинжилгээ

3.1. Усан орчинд узуулэх нөлөөлөл

- Уурхайн талбай дахь гуний худгаар дамжин гүний усанд бохирдол дамжих

3.2. Хяналт-шинжилгээ явуулах үзүүлэлт

- Усны чанарын үндсэн үзүүлэлт, Био идэвхит нэгдлүүд
- Cu, V, Cd, Cr, As, Se, Mo, Pb, F, %, Zn, CNнийг Нд зэрэг химийн элементийн тувшин

3.3. Хяналт-шинжилгээний төрөл хэлбэр

- Сорьц авч шинжилгээ хийлгэх

3.4. Байршил

- Уурхайн талбайд эргэлтийн усан сан, карьерийн усан сан
- Ахуйн зориулалтаар хэрэглэж буй ус /нянгийн үзүүлэлт/

3.5. Хэрэглэгдэх багаж төхөөрөмж

- Дээжлэгч болон цэвэрхэн усны шил, сав

3.6. Хийх ажлын дараалал

- Усны дээж авах саваа бэлтгэнэ, сайтар цэвэрлэсэн байна.
- Дээж авах гэж буй усаар сав болон бөглөөг 2-3 удаа зайлна.
- Бактериологийн шинжилгээ хийлгэхдээ тусгай ариутгасан саванд авна.
- Дээж авалт (дээж тус бүр хаягтай байна) .
- Итгэмжлэгдсэн лабораторит хүргүүлэн задлан шинжилгээ хийлгэнэ.

3.7. Хяналт-шинжилгээ явуулах хугацаа график

- 1 удаа

### 3.8. Аргачлал

- MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-Химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх
  - MNS 5667-10:2001 Усны чанар-Дээж авах-2-р булэг. Хаягдал уснаас дээж авах
  - MNS 5667-2:2001 Усны чанар-Дээж авах-2--р булэг Дээж авах арга
  - MNS 4867:1999 Усны чанар-Дээж авах-3-р булэг Авсан дээжийг зөөвөрлөх, хадгалах арга
- MNS (ISO) 5667-6:2001 Усны чанар Дээж авах, гүний уснаас дээж авах
  - Стандарт нормоор зөвшөөрөгдөх хэмжээ
- "Хүрээлэн буй орчинд нийлүүлэх цэвэршүүлсэн бохир ус, ерөнхий шаардлага"  
M NS4943 : 2011
  - Газрын доорх усыг бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ" MNS 6148:2010

## 5. 2021 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 5.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 9. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлсэн хугацаа, давтамж	Баримталсан эрх зүйн баримт бичиг
<b>1. Агаар орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд</b>								
Машин механизм, дизель станцын яндангаас ялгаран гарах утаан дахь агаар бохирдуулагч хорт хийнүүд орчинд тархах	Уурхайн бүх төрлийн машин механизмуудыг оношлогоо засварыг тогтмол хийж гүйцэтгэж байсан	Бүх машин механизмууд	ш	5	Үйл ажиллагааны зардлаар		байнга	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 4585:2007 MNS 5919:2008
Салхи ихтэй, хуурайшилтай үед их хэмжээгээр тоос шороо дэгдэх, машин механизмыг богино зайд олон эргэлтэйгээр ашигласнаас агаар дахь тоосжилт ихсэх	Уурхайн замуудад усалгаа хийх замаар тоосжилтийг бууруулах	Уурхайн дотоод замуудад	км	5			Тогтмол хийж гүйцэтгэсэн	

**2. Хөрсөн бүрхэвчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд**

Байнгын хөл хөдөлгөөнөөс байгууламжуудын ойр орчмын хөрсөн бүрхэвч доройтох, элэгдэл эвдрэлийн талбай нэмэгдэх	Уурхайн дотоод тээврийн замыг тэмдэгжүүлэх, баталсан маршрутаар явуулж хэвшүүлэх, салаа зам гаргуулахгүй байх	Уурхайн дотоод замууд	ш	20	60	1200	байнга	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед шимт хөрс хуулалт, хадгалалт  MNS 5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт  Газрын тухай хууль 50 дугаар зүйл
	Шимт хөрсийг стандартын дагуу хуулан, бусад хөрс чулуулагтай холилдохгүй байх тал дээр анхааран зөв зохистой байршуулах, үржил шимт чанарыг алдагдуулахгүй байх тал дээр анхааран ажиллах	Төслийн хэмжээн	удаа	Хуулсан хөрсний хэмжээгээр	Хуулсан хөрс байхгүй			
<b>ДҮН</b>						<b>1200</b>		
<b>3. Ургамлан бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ</b>								
Уурхайн болон ажилчдын хотхоны үйл ажиллагааны улмаас ургамлан бүрхэвч устана	Уурхайн тосгоны талбайд ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэн бут сөөг тарих, зүлэгжүүлэх	Уурхайн тосгон	м2	50	30	1500	Ургамал ургалтын хугацаанд багтаан хийж гүйцэтгэх	MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах
<b>ДҮН</b>						<b>1500</b>		

4. Газрын доорх усанд үзүүлэх нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд								
Уурхайн орчмын газрын доорхи усны түвшин буурч, нөөц багасах, бохирдол үүсэх	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар-аар ус ашиглуулах дүгнэлт гаргуулсан	Төслийн хэмжээнд	удаа	1	850	850		MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах
	Ус ашиглах төлбөр төлөх		м3	1	УАЗ	УАЗ	Усны гэрээ байгуулахаас өмнө 35 сая төгрөг төлсөн	
	Тунгаагуур нуурууд болон уурхайн унд ахуйд хэрэглэж буй усны эх үүсвэрүүд зэргээс тогтмол хугацаанд дээж авч бохирдолыг хянаж ажиллах замаар үүсэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх		удаа	2	ОХШХ-ийн зардлаар		2021 оны 2 болон 3 р улиралд 2 удаа хийлгэсэн	
<b>ДҮН</b>					<b>850+УАЗ+ОХШХ зардал</b>			
5. Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд								
Амьтны тоо толгой буурах, дайжих, амьдрах орчин нь устах, идэш тэжээл нь хомстохоос хамгаалах	Үлийн цагаан оготно ихээр тархсан бэлчээрт махчин шувууны үүрнүүд байршуулах, Заамар сумын ЗДТГ, байгаль орчныг хамгаалах албанаас зөвлөгөө авах	Төсөл хэрэгжих талбайн ойролцоох бэлчээр нутагт	ш	0	50	0	хэрэгжээгүй	Амьтны тухай хууль



ДҮН						0		
<b>НИЙТ ДҮН</b>						<b>3040</b>		

## 5.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Угаагдаж гарсан эфель гаалийг өмнө олборлолт явуулж байсан талбайд угааж байгаа бөгөөд энэ нь нөхөн сэргээлтийн ажлын хэмжээг хэмнэх давуу талтай байна.

Хүснэгт 10. Нөхөн сэргээлийн ажлын зардал

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээх арга хэмжээ	Хэмжих нэгж	Төлөвлөгөө		Биелэлт		Хэрэгжүүлсэн хугацаа
				Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	
1	Техникийн нөхөн сэргээлт	Гадаад овоолго	Га	1,7	5	2,4 га	10,5	8-10 саруудад
		Дотоод овоого	м3	71 000	8	293 000 м3	ҮАЗардалд	6-8 саруудад
2	Биологийн нөхөн сэргээлт	Шимт хөрсөөр хучих	Га	3,4	5	4,02 га	ҮАЗардалд	7 сард
		Олон наст ургамал тарих	га	3,4	15	4,02 га	25	10 сард
3	Биологийн нөхөн сэргээлт “Тэрбум мод” хөтөдлбөр	БНС	шир	5000	10	6000	12,5	9-10 саруудад
<b>НИЙТ</b>							<b>48,0</b>	

### 5.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтийн тайлан

Хүснэгт 11. Дүйцүүлэн хамгаалах ажлын зардал

ДХ зорилт	Хамгааллын арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлсэн хугацаа	Баримтлах стандарт, аргачлал
Уул уурхайн ашигт малтмалын ашиглалтын үлдэгдэл нөлөөлөд өртөн нөхөн сэргээхгүй газрын биологийн олон янз байдлыг төлөөлүүлэн өөр газарт хамгаалах	Орон нутгийн удирдлагуудаар ДХ хийх ажлын чиглэлээр санал авах	Баянголын аманд 5 га газарт техникийн нөхөн сэргээлт	удаа	3,88 га	42,5	10 сард	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31 дүгээр заалт
<b>НИЙТ</b>					<b>42,5</b>		

### 5.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Ашигт малтмалын талбай болон түүний нөлөөллийн бүсэд нүүлгэн шилжүүлэлт хийх айл өрх байхгүй. Уурхайн нь үйл ажиллагаа явуулж дууссаны дараа уурхайн хаалт болон нүүлгэн шилжүүлэлт хийгдэнэ.

### 5.5 Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тус уурхай нь өнөөг хүртэл ажиллах хугацаанд төслийн талбай болон түүний эргэн тойрноос ямар нэгэн түүх соёлын өв илрээгүй болно.

## 5.6 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Энэхүү төслийг хэрэгжүүлэх явцад ямар нэгэн байдлаар нэмэлтээр хиймийн бодис болон тэсэлгээний ажил хийгдээгүй тул химийн бодисоос үүсэх осол эрсдэл байхгүй болно.

Хүснэгт 12. Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний зардал

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Зардал, мян.төг		Хэрэгжүүлсэн хугацаа	Баримталсан стандарт, дүрэм, журам
				Нэгж	Нийт		
Байгалийн гамшиг, аюул ослоос үүсэх эрсдэлүүд	Байгалийн аюул гамшгийн үед авах арга хэмжээний талаар нийт ажиллагсадын дунд сургалт зохион байгуулах	Уурхайн бүх ажиллагсад	1	ХАБЭА-ын зардалд		6-р сард зохион байгуулсан	Гамшгаас хамгаалах тухай хууль,
	Уурхайн тосгон болон хаягдлын сангийн эргэн тойронд үерийн уснаас хамгаалах суваг, шуудуу, хамгаалах далан хаалт байгуулах					2021 онд хийгдсэн	
Төслийн үйл ажиллагаанд техникийн зориулалттай шатах, тослох материалын аюулгүй ажиллагааг хангах	Ажиллагсадын цахилгаан хэрэгсэлтэй харьцаж ажиллах арга ажиллагаанд сургаж, гал түймрийн үед хэрхэн ажиллах талаар сургалт зохион байгуулсан					5-р сард сургалт хийгдсэн	
				ХАБЭА-ын зардалд тусгагдсан			

### 5.7 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Энэхүү төслийг хэрэгжүүлэх явцад ямар нэгэн байдлаар нэмэлтээр хиймийн бодис болон тэсэлгээний ажил хийгдээгүй тул химийн бодисоос үүсэх осол эрсдэл байхгүй болно.

Хүснэгт 13. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт

Хаягдлын төрөл	Эх үүсвэр	Зайлуулах/устгах болон дахин ашиглах арга
Автомашинд ашиглагдсан хаягдал тос, тосны фильтр	Засварын газар, засвар үйлчилгээний машин	Талбай дээр цуглуулан хуримтлуулж, дахин боловсруулах цэгт нийлүүлэгдсэн болно.
Хаягдал тосны савнууд		
Ердийн хог хаягдал. Тухайлбал, биологийн задралд хялбар ордог органик /хоолны хаягдал/, дахин боловсруулахад тохиромжгүй зарим хуванцар болон цаас	Уурхайн тосгон, захиргааны байр болон засварын газар	Талбай дээр цуглуулан хуримтлуулж, дахин боловсруулах цэгт нийлүүлэгдсэн болно. Хоолны хаягдалыг багийн гахай тэжээх аж ахуй авдаг болно.
Дахин боловсруулах боломжтой хог хаягдал. Тухайлбал цаас цаасан хайрцаг, хуванцар шил хөнгөн цагаан лааз		
Ашиглагдсан дугуй	Засварын газар	Бүх төрлийн дугуйнуудыг баяжуулах үйлдвэрийн суурийн бэхэлгээнд ашиглаж байгаа
Автомашинны аккумулятор		Тусгайлан хадгалж, дахин ашиглуулахаар нийлүүлсэн

Хүснэгт 14. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний зардал

Хаягдлын төрөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлсэн хугацаа
Ахуйн гаралтай хог хаягдал	Ахуйн гаралтай хог хаягдлыг өмнөх онуудад бий болгосон хогийн цэгт төвлөрүүлэн хуримтлуулсан	Төслийн хүрээнд	Тн		Гарсан хэмжээгээр	Тухай бүрт ҮАЗардалд	
	Хог хаягдлыг гэрээг СЗД-тай байгуулан, төлбөрийг төлөх		удаа		1	1000	2022.2.03 нд байгуулсан
Үйлдвэрийн гаралтай хог хаягдал	Хоосон чулуулгийн хог хаягдлыг өмнөх онуудад бий болсон карьерийг булах, нөхөн дүүргэх ажлуудыг зохион байгуулах		Мян.м3	ҮАЗардалд	210	Техникийн нөхөн сэргээлт дотоод овоолго	
Аюултай хог хаягдал	Санамсар болгоомжгүйгээр ШТМ болон бусад аюултай шингэн хог хаягдал хөрсөнд ил задгай асгарсан тохиолдолд даруй тухайн хөрсийг хуулан авч, саармагжуулах, хоргүйжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	АМТЗ-ийн талбай болон засварын талбайн хэмжээнд	удаа		5		Нөхцөл байдал үүсээгүй
	Төсөлд ашиглагдаж буй тээврийн хэрэгслүүдэд ашиглагдсан аккумулятор, тос тосны шүүр, фильтр зэргийг тусгайлан ангилж, агуулахад хадгалах ба тусгай зөвшөөрөл бүхий байгуулагад нийлүүлэх замаар эх үүсвэр дээрээс нь аюулгүйгээр зайлуулах	Төслийн хэмжээнд	Удаа	ҮАЗардалд			Аккумуляторуудыг малчид үнэ төлбөргүй авч нарны үүсгүүрт дахин хэрэглэдэг, шүүр фильтр хадгалдаг
<b>НИЙТ ДҮН</b>					<b>1000</b>		

### 5.8 Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн биелэлт

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар уг төслийг хэрэгжүүлэхдээ тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалах, зүй зохисто ашиглах, төсөл хэрэгжиж буй орчинд бий болзошгүй сөрөг үр дагаварыг хянах, илрүүлэх зорилгоор орчны хяналт-шинжилгээ хийгдэнэ гэж төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу жилд 2 удаа хийж гүйцэтгэсэн болно.

Хүснэгт 14. Орчны хяналт-шинжилгээний зардал

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэг	Төлөвлөсөн давтамж	Хийгдсэн давтамж	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Баримтлах стандарт
<b>1. Агаарын чанар</b>						
Ялгарах бохирдуулагчид: SO <sub>2</sub> , CO, NO <sub>2</sub>	Уурхай талбай Ажилчдын хотхон	1	3	50	1500	MNS 4585:2016 MNS 5919:2008 MNS 5013:2001 MNS 4221:2002 MNS 5365:2004
Тоосны хэмжилт: PM10, PM2.5 Тоосны чөлөөт уналт, Тоосны найрлага, бүтэц тархалт		1	2	50	1500	
<b>2. Усан орчинд</b>						
Ca, Mg, Cl, NO <sub>2</sub> , NO <sub>3</sub> , HCO <sub>3</sub> , Fe, As, Na, K-ийн агууламж, амт, үнэр өнгө, рН, нийт ууссан хатуу биетийн хэмжээ, нийт хатуулаг, цахилгаан дамжуулах чадвар зэрэгт шинжилгээ хийлгэх	Уурхайн унд ахуйн ус болон технологийн тунгаах нуур, технологийн ус авч байгаа цэгээс дээж авч шинжлүүлсэн	2	3	50	1500	MNS 4586:1998 MNS 0900:2005 MNS 6148:2010 MNS 4867:1999 MNS 5667 11:2000 MNS 5667 1:2002

3. Хөрсөн бүрхэвч						
Хөрсний өнгөн болон дээд үе давхрагын чийгшил, рН, хүнд металл, нитрат, нитрит, хүүхрийн хүчил, нефть зэргийг шинжилүүлсэн	Эвдрэлд өртсөн болон бртөөгүй 4 цэгт дээж авч шинжлүүлсэн	1	3	404,5	1500,5	MNS 5850:2008 MNS 3297:1991 MNS 2305:1994 MNS 3298:1991
<b>НИЙТ ДҮН</b>				<b>6000,5</b>		

### 5.9 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт

Хүснэгт 14. Орчны хяналт-шинжилгээний зардал

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1	Сум, багийн удирдлага, ИТХ-тай хамтран ажиллах	70 сая	2023 онд	ҮАЗахирал	Заамар сумын засаг даргатай Байгаль орчныг хамгаалах, дэд бүтцийг хөгжүүлэх ажлын байр нэмэгдүүлэх /Нийгмийн хариуцлагын/ гэрээг байгуулан ажиллаж байна
2	Орон нутгийн иргэдэд байгаль орчны хамгаалах ажлаа тайлагнах	50	1 удаа	ҮАЗахирал	Багийн нийт иргэдийн Хаврын хуралд танилцуулсан, Намрын хурал хуралдаагүй
3	Ажиллагсадын хөдөлмөр хамгааллын хувцасаар хангах	ХАБЭА зард	2	ХАБЭА	
4	Ажиллагсадыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	ХАБЭА зард	1	ХАБЭА	
5	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан, дараа жилийн төлөвлөгөө боловсруулах	ҮАЗардалд	2023 оны 11 сард		
<b>НИЙТ</b>		<b>50+ХАБЭА+ҮАЗардал</b>			

## 5.10 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн нийт зардал

Хүснэгт 15. Нийт зардал

№	Арга хэмжээ	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт	3 040,0
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт	48 000,0
3	Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт	42 500,0
4	Нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөөний биелэлт	-
5	Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөөний биелэлт	-
6	Осол, эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт	ХАБЭА зардалд
7	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт	1 000,0
8	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөрийн биелэлт	6000,5
9	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт	50,0
<b>2021 оны БОМТөлөвлөгөөний биелэлтийн нийт зардал</b>		<b>100 590,5</b>



## АШ И ГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Байгаль орчны хуулийн эмхэтгэл, У.б., 2012
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, аудитын журам, аргачлал 2014 БОНХЯ
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан "ЭКО ТРЕЙД" ХХК
- 2004 он
- Доржготов Д., Монгол орны хөрс - газарзүйн мужлалт. УБ.1976
- Доржготов Д., Монгол улсын үндэсний атлас. ШУА, Газарзүйн хүрээлэн, УБ. 2009.
- Жадамбаа Н. доктор (Бс.О), батжаргал Д., "Газарзүйн үнэлгээний үнэлгээ", УБ.
- 2012.
- Монгол орны байгаль орчин, 1996
- Монгол орны геозкологийн асуудал. Монгол улс. ШУА-ийн Геозкологийн хүрээлэн. УБ.
- 2003
- Монгол орны гадаргын ус УБ. 1999 он
- Монгол орны геозкологийн асуудал. ШУА. Геозкологийн хүрээлэн. Улаанбаатар. 2008
- Монгол улсын стандарт"-ын жагсаалт
- "Монгол орны усны ай савуудаар газрын доорх усны нөөц баялгийн зураг зохиох, тооцоолон тодорхойлох арга зүй", 2010.
- Монгол улсын байгаль орчны төлөв байдлын тайлан. 2008-2010 он. БОАЖЯ
- Томоохон голуудын усны нөөц, усан орчны экологийн судалгааны материал
- Туваанжав Г., Монголчуудын нээлт бүтээл ба усны чанар судлал. УБ. 2011
- Туваанжав.Г. Мөнхзул.Д. Долгоржав.Л. Усны задлан шинжилгээний хими ба дүн боловсруулалт. Улаанбаатар. 2006

## **Хавсралт хэсэг**

Зураг 1. Ажилчидын хотхон. Ногоон байгууламж





Хавсралт Зураг 2,3 . Үрсэлгээний хүлэмж





Зураг 4,5, . Галын цэгүүд





Зураг 7. Шатахуун түлш хатгалах сав, түгээгүүр



Зураг 8. Ашигласан тосны хаягдлын сав.





Зураг 9. Ажилчдын усанд орох газар



Зураг 10. Ажилчидын бие засах газар.





Зураг 11. Зам талбай, дэд бүтэц







БАТЛАВ:

“АЛТАНГОВЬ ОУДМОЙН ХХК” ХХК-НИЙ

ЗАХИРАЛ




ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

/Б.БААТАРЦОГТ/



“ЭМ ЖИ ЖИ И СИ” ХХК-НИЙ

ЗАХИРАЛ



**ТОВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ АР  
НАЙМГАН 1 АЛТНЫ ҮҮСМЭЛ ШОРООН ОРДЫГ АШИГЛАХ  
ТЕХНИК-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДЭСЛЭЛ**

(Тусгай зөвшөөрлийн дугаар MV-004411, MV-004412, MV-000129 Хүчин чадал 24,000 м3/сар)

ХЯНАСАН:


ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН

САЛБАР ХУРАЛДААНЫ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА *Д.Маасүрэн* Д.МААСҮРЭН

ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАГЧ:

УУЛ УУРХАЙН ЗУРАГ ТӨСӨЛ, СУДАЛГААНЫ “МАЙНИНГ ШОРТ ЛОНГ ТЕРМ”

ХХК-НИЙ ЗАХИРАЛ



Н.ЦЭДЭВДОРЖ

ЗӨВЛӨСӨН:

МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР

Ч.ЭНХБАЯР



ТӨСЛИЙН ШИНЖЭЭЧ:

МОНГОЛ УЛСЫН ЗӨВЛӨХ ИНЖЕНЕР

Ж.БААТАР



Улаабаатар хот

2016 он



Батлав: Байгаль орчин аялал жуулчлалын яамны

Ерөнхий шинжээч



Г.НЯМДАВАА

“ТЭЛМЭН МАНДАЛ”  
ХХК



ТӨСЛИЙН БАЙГАЛЬ  
ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН  
ҮНЭЛГЭЭ

Шүүмж хийсэн: Байгаль орчин аялал жуулчлалын яамны шинжээч

**ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН НУТАГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ АР НАЙМГАН -  
1 ҮҮСМЭЛ АЛТНЫ ШОРООН ОРД ОЛБОРЛОХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ  
ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН,  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Үнэлгээ хийсэн мэргэжлийн байгууллага: “ТЭЛМЭН МАНДАЛ” ХХК

Захирал:



Т. ЭНХ-АМГАЛАН/

Төсөл хэрэгжүүлэгч:

Захирал



“ЭМ ЖИ ЖИ И СИ” ХХК

Д.МАНДУУЛ/

Улаанбаатар хот  
2017 он






Байгаль орчны үнэлгээ, зөвлөх үйлчилгээний  
“ГРИН СОЛЮШН КОНСАЛТИНГ” ХХК

БАТЛАВ. БОАЖЯ-ны  
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ:

ХЯНАСАН. БОАЖЯ-ны  
ШИНЖЭЭЧ:



П.ЦОГТСАЙХАН

**“ЭМ ЖИ ЖИ И СИ” ХХК-ИЙН ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН  
НУТАГТ ОРШИХ MV-004411, MV-004412, MV-000129 ТООТ  
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛҮҮДТЭЙ “АР НАЙМГАНЫ  
АЛТНЫ ҮҮСМЭЛ ШОРООН ОРД-1” ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ  
НӨЛӨӨЛЛИЙН НАРИЙВЧИЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТОДОТГОЛ  
ТАЙЛАН**

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:  
ЗАХИРАЛ .....

“ГРИН СОЛЮШН КОНСАЛТИНГ” ХХК-ИЙН  
Б. ТУНСАГ

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ: ЭМ ЖИ ЖИ И СИ ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ .....

Э.ЗОЛЗАЯА




Улаанбаатар хот  
2020 он





Байгаль орчны үнэлгээ, зөвлөх үйлчилгээний  
“ГРИН СОЛЮШН КОНСАЛТИНГ” ХХК

БАТЛАВ. БОАЖЯ-ны  
ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ:



П.ЦОГТСАЙХАН

**“ЭМ ЖИ ЖИ И СИ” ХХК-ИЙН ТӨВ АЙМГИЙН ЗААМАР СУМЫН  
НУТАГТ ОРШИХ MV-004411, MV-004412, MV-000129 ТООТ  
АШИГЛАЛТЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛҮҮДТЭЙ “АР НАЙМГАНЫ  
АЛТНЫ ҮҮСМЭЛ ШОРООН ОРД-1” ТӨСЛИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ  
ОРЧНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР**

2020 он-2023 он

ТАЙЛАН БОЛОВСРУУЛСАН:  
ЗАХИРАЛ .....



“ГРИН СОЛЮШН КОНСАЛТИНГ” ХХК-ИЙН  
Б. ТУНСАГ

ТӨСӨЛ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:  
ЗАХИРАЛ .....



“ЭМ ЖИ ЖИ И СИ” ХХК-ИЙН  
Э.ЗОЛЗАЯА

Улаанбаатар хот  
2020 он

## ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАНГУУДЫГ ХАВСРАЛТ ФАЙЛААР ИЛГЭЭВ



**“МАРХАЛ ТАЛ” ХХК**

**Байгаль орчны аудит, байгаль орчны менежментийн зөвлөх үйлчилгээ**

## **БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВЛӨГӨӨТ АУДИТЫН ТАЙЛАН**

**ТӨСӨЛ: “ЭМ ЖИ ЖИ И СИ” ХХК-ИЙН ТӨВ АЙМГИЙН ЗААМАР  
СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАМГАНЫ ДООД ХЭСЭГ” MV-00129  
ДУГААРТ ТАЛБАЙ ДАХЬ АЛТНЫ ҮҮСМЭЛ ОРДЫГ ОЛБОРЛОХ  
УУРХАЙ**

**Улаанбаатар хот  
2019 оны VII сар**



“МАРХАЛ ТАЛ” ХХК



ТӨСЛИЙН БАЙГАЛЬ  
ОРЧНЫ АУДИТ

**“ЭМ ЖИ ЖИ И СИ” ХХК-ИЙН ТӨВ АЙМГИЙН  
ЗААМАР СУМЫН НУТАГТ ОРШИХ “АР НАМГАНЫ  
ДООД ХЭСЭГ” МУ-00129 ДУГААРТ ТАЛБАЙ ДАХЬ  
АЛТНЫ ҮҮСМЭЛ ОРДЫГ ОЛБОРЛОХ УУРХАЙН  
ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ АУДИТЫН ТАЙЛАН**

**АУДИТ ХИЙСЭН МЭРГЭЖЛИЙН  
БАЙГУУЛЛАГА:**

“МАРХАЛ ТАЛ” ХХК-ИЙН БАЙГАЛЬ  
ОРЧНЫ АХЛАХ АУДИТОР

**ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ ХҮЛЭЭСЭН:**

“ЭМ ЖИ ЖИ И СИ” ХХК -ИЙН  
ЗАХИРАЛ



Л.БАДАМСҮРЭН/



Г.ЗОЛЗАЯА/

Улаанбаатар хот  
2019 оны VII сар







